



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Булган АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/04/НА-СТА-ТӨХК

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Булган аймаг  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: **7034-2716**

Цахим хаяг: : [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид

Утас: **9511-2689**

Цахим хаяг: [tsesb.audit@gmail.com](mailto:tsesb.audit@gmail.com)

Аудитор Ш.Ганчимэг

Утас: **99377360**

Цахим хаяг: [shagdarganchimeg44@jmail.com](mailto:shagdarganchimeg44@jmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	7
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	0
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл ..	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.1 Байгууллагын үйл ажилагаа .....	1
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	1
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. Аудитын тайлан .....	0
4.1 Ерөнхий зүйл .....	6
4.2 Дотоод хяналт .....	6
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4 Материаллаг байдал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	<b>Error! Bookmark not defined.</b>
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
8. Аудитын илрүүлэлт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
8.2 Төлбөрийн акт .....	8
8.3 Албан шаардлага.....	8
8.4 Зөвлөмж.....	9
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.09.15 № 272  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

"БУЛГАН АЗЗА" ТӨХК-ИЙ ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Э.ПҮРЭВДЭМБЭРЭЛ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Булган АЗЗА" ТӨХК-ий 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Булган АЗЗА" ТӨХК-ий 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны эцэст нийт авлагын дүн 571.6 сая төгрөг байгаа нь өмнөх оны гүйцэтгэлээс 44.5 хувиар буюу 267.9 сая, төлөвлөснөөс 57.3 хувиар буюу 327.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Дээрх авлагаас 371.6 сая төгрөгийн авлага нь тайлант онд шинээр үүссэн бөгөөд үүнээс 14 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах 213.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Тайлант онд автомашин, механизмын 67.8 сая төгрөгийн сэлбэг материалыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэлгүйгээр шууд гэрээ байгуулж, худалдан авсан.

D:/bichighereg/2023A4toot

006020317

Автомашинуудын километрийн спидометр ажилладаггүй, явсан км тодорхой бус, шатахууны тооцоо, тайлан хангалтгүй, зарцуулалтад хяналт тавих боломжгүй байна.

Жилийн эцсийн тооллогоор кассаас дутагдсан 3.5 сая төгрөг, шүүхийн шийдвэрээр хувь хүнээр төлүүлэх автомашин үнэ 12.8 сая төгрөгийг тус тус санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-д заасантай нийцэхгүй, эрх үүрэг, үнэн зөв, бодитой, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Нийт зардалд 1,908.7 сая төгрөг төсөвлөсөн ба 1,911.3 сая төгрөгийг зарцуулсан, төлөвлөгөө 100,1 хувийн гүйцэтгэлтэй, үүнээс удирдлагын зардал 274.7 сая төгрөг төсөвлөснөөс 261.5 сая төгрөгийн зарцуулалттай, гүйцэтгэл 95.2 хувь буюу 262.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### **Аудитын гол асуудал**

2009 оны Зам тээврийн яамны тушаал, Төрийн өмчийн хорооны тогтоолоор Кувейтийн сангийн зээлээр бэлтгэсэн 17 нэр төрлийн машин тоног төхөөрөмжийн 565.2 сая төгрөгийн урт хугацаат зээл дансанд бүртгэлтэй шийдэгдээгүй, мөн 2021 онд Зам, тээврийн хөгжлийн яамнаас хүлээлгэж өгсөн усны МАЗ /3505/ болон нөхөөсний БИС /310М/ маркийн машин нь тооллогын бүртгэлд байгаа ч үнэ тодорхойгүй шалтгаанаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаагаагүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

2022 оны зорилтот түвшингээр 1,941.9 сая төгрөгийн орлоготой ажиллахаар төсөвлөсөн ба Зам Тээвэр Хөгжлийн Яамтай байгуулсан гэрээний дагуу замын сангийн хөрөнгөөр зам засвар арчлалтын ажлыг 1,367.8 сая төгрөгөөр хийж үлдсэн 574.1 сая төгрөгийн орлогыг орон нутгийн орлогоор бүрдүүлэх төлөвлөгөөг баталсан. Үүнээс Зам тээврийн хөгжлийн яамнаас 1,319.9 сая төгрөг, Орон нутгийн замын сангаас 584,4 сая төгрөгийн ажил хийж нийт орлого 98.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Автомашинуудын километрийн спидометр ажилладаггүй, явсан км тодорхой бус, шатахууны тооцоо, тайлан хангалтгүй, зарцуулалтад хяналт тавих боломжгүй байна.

Жилийн эцсийн тооллогоор кассаас дутагдсан 3.5 сая төгрөг, шүүхийн шийдвэрээр хувь хүнээр төлүүлэх автомашин үнэ 12.8 сая төгрөгийг тус тус санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-д заасантай нийцэхгүй, эрх үүрэг, үнэн зөв, бодитой, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Нийт зардалд 1,908.7 сая төгрөг төсөвлөсөн ба 1,911.3 сая төгрөгийг зарцуулсан, төлөвлөгөө 100,1 хувийн гүйцэтгэлтэй, үүнээс удирдлагын зардал 274.7 сая төгрөг төсөвлөснөөс 261.5 сая төгрөгийн зарцуулалттай, гүйцэтгэл 95.2 хувь буюу 262.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### **Аудитын гол асуудал**

2009 оны Зам тээврийн яамны тушаал, Төрийн өмчийн хорооны тогтоолоор Кувейтийн сангийн зээлээр бэлтгэсэн 17 нэр төрлийн машин тоног төхөөрөмжийн 565.2 сая төгрөгийн урт хугацаат зээл дансанд бүртгэлтэй шийдэгдээгүй, мөн 2021 онд Зам, тээврийн хөгжлийн яамнаас хүлээлгэж өгсөн усны МАЗ /3505/ болон нөхөөсний БИС /310М/ маркийн машин нь тооллогын бүртгэлд байгаа ч үнэ тодорхойгүй шалтгаанаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

2022 оны зорилтот түвшингээр 1,941.9 сая төгрөгийн орлоготой ажиллахаар төсөвлөсөн ба Зам Тээвэр Хөгжлийн Яамтай байгуулсан гэрээний дагуу замын сангийн хөрөнгөөр зам засвар арчлалтын ажлыг 1,367.8 сая төгрөгөөр хийж үлдсэн 574.1 сая төгрөгийн орлогыг орон нутгийн орлогоор бүрдүүлэх төлөвлөгөөг баталсан. Үүнээс Зам тээврийн хөгжлийн яамнаас 1,319.9 сая төгрөг, Орон нутгийн замын сангаас 584,4 сая төгрөгийн ажил хийж нийт орлого 98.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлтийн нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
31	<b>Мөнгөн хөрөнгө</b>	<b>443,400,122.23</b>	<b>575,688,444.44</b>
311	1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	142,891,742.67	6,203,390.96
33401	1.1.2. Дансны авлага	300,508,379.56	569,485,053.48
33405	1.1.4. Бусад авлага	1,012,955.04	2,087,624.43
35	1.1.6. Бара материал	153,341,181.71	206,225,437.49
34600	1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	97,731,699.51	
	<b>1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>695,485,958.49</b>	<b>784,001,506.36</b>
2	1.2. Эргэлтийн бус хөрөнгө		
39	1.2.1 Үндсэн хөрөнгө	932,123,055.21	873,645,904.53
392	1.2.2 Биет бус хөрөнгө	303,120,000.00	303,120,000.00
2	<b>1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,235,243,055.21</b>	<b>1,176,765,904.53</b>
3	<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,930,729,013.70</b>	<b>1,960,767,410.89</b>
41366	2.1.1.1 Дансны өглөг	777,850.41	165,411,961.30
41310	2.1.1.2 Цалингийн өглөг	0.00	15,495,233.38
41363	2.1.1.3 Татварын өр	28,021,266.49	100,260,540.72
41310	2.1.1.4 НДШ-ийн өр	0.00	44,570,546.57
41365	2.1.1.7 Ногдол ашгийн өглөг	4,088,835.00	
41	<b>2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>32,887,951.91</b>	<b>325,738,281.98</b>
422	2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	565,211,312.00	565,211,312.00
42	<b>2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>565,211,312.00</b>	<b>565,211,312.00</b>
4	<b>2.2 Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>598,099,263.91</b>	<b>890,949,593.98</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,332,629,749.79</b>	<b>1,069,817,816.91</b>
2.3	2.3 Эздийн өмч	1,098,247,184.14	1,098,247,184.14
2.3.1	2.3.1 Төрийн	1,098,247,184.14	1,098,247,184.14
2.3.2	2.3.2 Хувийн		
2.3.6	2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	752,128,121.46	752,128,121.46
2.3.7	2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	2.3.9 Хуримтлагдсан ашиг	(517,745,555.81)	(780,557,488.69)
2.3.11	2.3.11 Эздийн өмчийн дүн	1,332,629,749.79	1,069,817,816.91
	<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,930,729,013.70</b>	<b>1,960,767,410.89</b>

“ЦЭСБ аудит” ХХК

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
<b>1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)</b>	<b>1,497,068,903.00</b>	<b>1,904,360,105.00</b>
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,208,692,455.78	1,911,279,296.31
<b>3. Нийт ашиг (алдагдал)</b>	<b>288,376,447.22</b>	<b>(6,919,191.31)</b>
8. Бусад орлого	22,807,919.41	1,901,127.99
9. Борлуулалт, маркетингийн зардал	189,738,437.45	173,621,099.46
10. Ерөнхий ба удирдлагын зардал	11,034,600.71	24,024,483.78
11. Санхүүгийн зардал	7,033,656.34	39,700.00
12. Бусад зардал	94,291,373.42	60,108,572.82
<b>18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>9,086,298.71</b>	<b>(262,811,919.39)</b>
19. Орлогын татварын зардал	908,630.00	
<b>20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>8,177,668.71</b>	<b>(262,811,919.39)</b>
<b>21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагд)</b>		
<b>22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>8,177,668.71</b>	<b>(262,811,919.39)</b>
<b>24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>		
<b>25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

“ЦЭСБ аудит” ХХК

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,098,247,184.14			752,128,121.46			(517,745,555.81)	1,332,629,749.79
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(262,811,919.39)	(262,811,919.39)
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн								
9	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,098,247,184.14			752,128,121.46			(780,557,488.69)	1,069,817,816.91

“ЦЭСБ аудит” ХХК

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>1,765,325,486.00</b>	<b>1,898,971,896.11</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		125,421,599.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,441,200.00	996,436.40
Бусад мөнгөн орлого	1,762,884,286.00	1,772,553,860.71
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>1,548,183,085.98</b>	<b>2,031,571,412.82</b>
Ажиллагчдад төлсөн	326,941,493.60	352,104,916.70
Нийгмийн даатгалын байгуулгад төлсөн	120,490,101.41	77,978,871.83
Бараа материал худалдан авахад төлсөн	627,780,068.37	923,986,869.17
Ашиглалтын зардал төлсөн	80,000.00	711,790.29
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	25,000.00	
Татварын байгуулгад төлсөн	150,242,960.74	49,864,033.45
Даатгалын төлбөрт төлсөн	1,589,100.00	
Бусад мөнгөн зарлага	321,034,361.86	626,924,931.38
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>217,142,400.02</b>	<b>132,599,516.71</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>2,231,428.10</b>	
Мөнгөн орлогын дүн	2,231,428.10	
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	2,231,428.10	
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>2,231,428.10</b>	
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	100,000,000.00	9,974,470.00
Мөнгөн орлогын дүн		
Мөнгөн зарлагын дүн	100,000,000.00	9,974,470.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	100,000,000.00	5,885,635.00
Төлсөн ногдол ашиг		4,088,835.00
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>114,910,971.92</b>	<b>142,573,986.71</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	114,910,971.92	142,573,986.71
<b>Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>25,709,342.65</b>	<b>142,891,742.67</b>
<b>Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>142,891,742.67</b>	<b>6,203,390.96</b>

### **3. Санхүүгийн тайлангийн тодруулга**

---

#### **3.1 Байгууллагын үйл ажиллагаа**

“Булган АЗЗА” ТӨХК нь “Олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам, төмөр бетон гүүр хоолойн засвар арчлалтын ажлыг хариуцан авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг байнга ханган ажиллахыг эрхэмлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авто зам, зам байгууламжийг барих, засварлах гэж тодорхойлсон, улсын бүртгэлийн гэрчилгээнд “хувьцаат компани” гэж бүртгэсэн бөгөөд өмчийн 100 хувийг төр эзэмшдэг төрийн өмчит хувьцаат компани байна.

2022 онд 32 орон тоотой, үйлдвэрлэл явуулах хүчин чадлаа нэмэгдүүлэн 23 тээврийн хэрэгсэл, 22 механизм, 27 техник тоног төхөөрөмжтэй Зам засварлах, барих нөхцөлийг бүрдүүлэн ЗТХЯ-тай байгуулсан гэрээний дагуу хариуцсан Олон улсын болон улсын чиглэлийн замын засвар арчлалтын ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэхийн зэрэгцээ аймаг орон нутгуудад зарлагдсан тендерт оролцон цаг хугацаанд нь хийж хүлээлгэн өгч, зорилтод түвшиний төлөвлөгөөний дагуу ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Тус компани нь анх Булган аймгийн Зам анги нэртэй 1941 оны 6 сард 5 орон тоотой, 5 тн-ын даацтай Полу маркын автомашинтай үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Монгол улсын засгийн газрын 2006 оны 173 тоот тогтоолоор “Булган АЗЗА” ТӨХК болсон энэ хугацаанд зам засвар, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх замаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон зорчигчдын тав тухтай аялах нөхцлийг ханган ажиллаж байна.

“Булган АЗЗА” ТӨХК нь 204,1 км асфальт бетон хучилттай зам, 38,76 км хайрган хучилттай зам, 145,64 км ердийн болон сайжруулсан хөрсөн зам бүгд 388,5 км Олон улсын болон улсын чанартай замын бэлэн байдлыг хариуцсан ажилладаг. Үүнд: А0901 дугаартай Булган-Дашинчилэн чиглэлийн 71,5 м, А0902 дугаартай Булган-Мөрөн чиглэлийн 158 км, А1002 дугаартай Эрдэнэт-Булган чиглэлийн 24,1 км, А13 дугаартай Хутаг-Өндөр-Тэшиг-Улсын хил чиглэлийн 134,9 км зам хариуцдагаас гадна Эгийн гүүр, Гуртын гүүр, Орхоны гүүр, орон нутгийн чанартай Хялганатын болон Хануйн гүүрүүд багтдаг байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь заалтуудтай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 9 хүнтэй томилсон байна. “Булган АЗЗА” ТӨХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 233.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой, /*Зам тээврийн яамнаас олгодог зам засвар, арчлалтын санхүүжилттэй холбогдох*/
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компаний мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн үед мөрдөгдөж байсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байсан хэдий ч 2019-2021 онд шинэчлэгдсэн хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байна.

Тус компаний гүйцэтгэх захирлын 2021 оны 1-р сарын 26-ны өдрийн А/04 тоот тушаалаар Дотоод хяналт шалгалтын комисс байгуулсан боловч тайлант онд шалгалтын ажлын төлөвлөгөө боловсруулж шалгасан материал бидэнд ирүүлээгүй. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/25 дугаар тушаалаар баталсан ч хангалтгүй ажилласан байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Булган АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Булган АЗЗА” ТӨХК нь 2019 оны Зам, тээврийн хөгжлийн яамны авто замын салбарын “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Уг НББ-ын бодлогын баримт бичгийг Зам, тээврийн хөгжлийн яамны сайдын тушаалаар батлуулаагүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

“Булган АЗЗА” ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30,038.4 мянган төгрөгөөр буюу 1.56 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	142,891.7	6,203.4	(136,688.3)
Авлага	300,508.4	569,485.1	268,976.7
Бусад авлага	1,013.0	2,087.6	1,074.6
Бараа материал	153,341.2	206,225.4	52,884.2
Урьдчилж гарсан тооцоо	97,731.7		(97,731.7)
Үндсэн хөрөнгө	1,235,243.1	1,176,765.9	(58,477.2)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,930,729.0</b>	<b>1,960,767.4</b>	<b>30,038.4</b>
Богино хугацаат өр төлбөр	32,888.0	325,738.3	292,850.3
Урт хугацаат өр төлбөр	565,211.3	565,211.3	0.0
Эздийн өмч	1,332,629.7	1,069,817.8	262,811.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,930,729.0</b>	<b>1,960,767.4</b>	<b>30,038.4</b>

“Булган АЗЗА” ТӨХК 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 784,001.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 1,176,765.9 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй нийт хөрөнгийн хэмжээ 1,960,767.4 мянган төгрөг байна.

#### Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 136,688.3 мянган төгрөгөөр буурсан нь 1,898,971.9 мянган төгрөгийн орлого олж, 2,035,660.2 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна. Тайлант хугацааны эцэст харилцах дансанд 353.7 мянга, касс дахь бэлэн мөнгө 5,849.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор кассаас дутагдсан 3,550.2 мянган төгрөгийг төлүүлээгүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

#### Авлага

Тайлант оны эцэст нийт авлагын дүн 571,572.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оны гүйцэтгэлээс 44.5 хувиар буюу 267,963.8 мянга, төлөвлөснөөс 57.3 хувиар буюу 327,585.1 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Дээрх авлагаас 371,651.8 мянган төгрөгийн авлага нь тайлант онд шинээр үүссэн бөгөөд үүнээс 14 иргэн, аж ауйн нэгж байгууллагаас авах 213,623.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Авлагын үлдэгдэлд Асгат өргөө ХХК-ийн 32,283.0 мянга, Эрдэнэтийн тендер Эмнэлгийн замын гүйцэтгэл Д.Энхээгийн 40,167.3 мянга, иргэн Н.Өлзийсайханаас 42,870.2 мянга, Бугат сумын зам засварын дуусаагүй үлдэгдэл 78,585.8 мянга, “Тавилан” ХХК-ийн 80,000.0 мянга, Зам, тээврийн хөгжлийн яамны санхүүжилтийн 144,292.0 мянга, дараа тайлангийн урьдчилгаа 30,088.3, ажилчдаас авах 5,076.7 мянган төгрөгийн авлага тус тус эзэлж байна. Тайлангийн хугацаанд найдваргүй авлагын тооцоо хийгдээгүй байна.

#### Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 206,225.4 мянган төгрөг болж 52,884.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан бараа материалаас зарцуулсан бараа материал бага байгаатай холбоотой. Үүнд үнийн өсөлт ч мөн нөлөөлжээ.

Тайлант онд худалдан авалтаар 778,963.4 мянган төгрөгийн бараа материалаар худалдан авч 741,006.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

2022 оны 11 сарын 26 ны өдрийн А/30 тоот тушаараар бараа материалын жилийн эцсийн тооллогыг хийж гүйцэтгэсэн байна. Тайлангийн хугацааны эцэст 206,062,1 мянган төгрөгийн бараа материалын 31,7 хувь буюу 65,312.2 мянган төгрөгийг сэлбэг хэрэгсэл, 22.9 хувь буюу 47,170.9 мянган төгрөгийг аж ахуйн бараа материал эзэлж байна. Түүнчлэн 62,500.0 мянган төгрөгийн материалыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэж үлдэгдлээр тайлагнасан, оны эхэнд үлдэгдэлтэй байсан 67,666.7 мянган төгрөгийн сэлбэгээс тайлант онд зарлага гараагүй байгаа нь

Бараа материал дансны тодруулга хангалтгүй, нярав солигдох үед бараа материалыг нярав хооронд шилжүүлснээс ерөнхий журналд орлого, зарлага давхар бичигддэг, үлдэгдлийг олон төрлөөр салгаж гаргаж байгаа нь ойлгомжгүй, аудитын явцад хүндрэл учруулж байлаа.

#### Урьдчилж гарсан зардал

Урьдчилж гарсан зардал данс эхний үлдэгдэлгүй байсан ба тайлант онд 97,731.6 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн оны эцэст энэ үлдэгдлээрээ байна. Энэ нь Орхон аймагт зам засварын ажил 30,000.0 мянган төгрөг, УБ-Дархан чиглэлийн зам засвар арчлалтын түр замын ажил 46,546.2 мянган төгрөг байна.

Оны эхэнд үлдэгдэлтэй байсан 67,666.7 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнасан, зам засварын ажилд зарцуулсан 62,500.0 мянган төгрөгийн материалыг дуусаагүй үйлдвэрлэл бусад гэсэн дансанд бүртгэж, үлдэгдлээр тайлагнасан нь тайлант хугацааны зардлыг багасгахад нөлөөлсөн байна.

#### Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө 1,176,765.9 төгрөг болж 58,477.2 мянган төгрөгөөс өссөн нь 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу асфальт зовуд 68,000.0 мянган төгрөг, авто замын индүү 20,000.0 мянган төгрөгөөр, зөөврийн вогончик 3,000.0 мянган төгрөг, бусад жижиг тавилга 7,600.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авч, тайлант онд 157,077.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Жилийн эцэст 1181 БУЛ дугаартай автомашин тоологдоогүй байхад үндсэн хөрөнгийн бүртгэлтэй тулгаж баталгаажуулаагүй, уг машин нь эзэмшигчийн буруу үйлдлээс шатсан, байгууллагад учирсан хохирол 12,800.0 төгрөгийг хариуцагч Н.Отгон-Очиороо төлүүлэхээр сум дундын Шүүхийн захирамж гарсан ч төлбөр төлөгдөөгүй, данснаас хасч, авлагад бүртгээгүй байна. Мөн өмнөх онд Зам, тээврийн хөгжлийн яамнаас хүлээлгэж өгсөн усны МАЗ /3505/, нөхөөсний БИС /310М/ маркийн тусгай зориулалтын автомашинууд нь тооллогын бүртгэлд байгаа ч үнэ тодорхойгүй шалтгаанаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгагдаагүй байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөөс шилжүүлсэн болон акталсан хөрөнгө байхгүй байна.

#### Өр төлбөр

Богино хугацаат өглөг оны эхэнд 32,887.9 мянган төгрөг байсан бол оны эцэст 325,738.3 мянган төгрөг болж бараг 10 дахин буюу 292,850.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өглөг нэмэгдсэн нь Даш зам ХХК-д асфальт бетон заводын 68,000.0 мянга, Сод монгол групп шатахууны 42,949.6 мянга, Татварын хэлтэст 100,260.5 мянга, НДШ-ийн 44,570.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.

Мөн 2009 онд Зам тээврийн яамны тушаал, ТӨХ-ны тогтоолоор Кувейтын сангийн зээлээр бэлтгэсэн 17 нэр төрлийн машин тоног төхөөрөмжийн 565,211.3 мянган төгрөгийн урт хугацаат зээл дансанд бүртгэлтэй, одоо болтол шийдэгдээгүй байна.

Хуримтлагдсан ашиг 780,557.5 мянган төгрөг болж 262,811.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд алдагдалтай ажилласантай холбоотой байна.

### 3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Булган АЗЗА” ТАУЗ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Зорилтот түвшний төлөвлөгөө, биелэлт

<i>Хүснэгт 2</i>		<i>/мянган төгрөгөөр/</i>			
д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2022 он		зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувиар	дүнгээр
1	<b>Нийт орлого</b>	<b>1,941,912.7</b>	<b>1,904,360.1</b>	<b>98.1</b>	<b>(37,552.6)</b>
	Үүнээс: Улсын чанартай ЗЗА	1,367,863.9	1,319,965.4	96.5	(47,898.5)
	Бусад	574,048.8	584,394.7	101.8	10,345.9
2	<b>Нийт зардал</b>	<b>1,908,738.1</b>	<b>1,911,279.3</b>	<b>100.1</b>	<b>2,540.9</b>
	Үүгээс: Удирдлагын зардал	274,729.6	261,499.3	95.2	(13,230.3)
3	Татварын өмнөх ашиг	33,174.6	(262,811.9)	(792.2)	(229,637.3)
4	Цэвэр ашиг/ алдагдал/	29,857.2	(262,811.9)	(880.2)	(232,954.7)
5	Төсвийн төлбөрт	200,368.1	225,073.8	112.3	24,705.7
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	4,478.5	-	-	(4,478.5)
7	Ажиллагсдын тоо	45	32	71.1	(13)
8	Цалингийн сан	427,620.0	489,708.4	114.5	62,088.4
9	Нэг ажилтны дундаж цалин	791.9	1275.3	161.0	483.4
10	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	0.983	1.004		0,021

ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 666 дугаар тогтоолоор “Булган АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Зам, тээврийн хөгжлийн яамтай байгуулсан гэрээний дагуу А0902 дугаартай Булган-Мөрөн чиглэлийн 158 км замд 630,115.1 мянга, А13 дугаартай Хутаг-Өндөр-Тэшиг улсын хил чиглэлийн 134 км замд 166,525.1 мянга, А1002 дугаартай Эрдэнэт-Булган чиглэлийн 24км замд 116,525.1 мянган, А0901 дугаартай Дашинчилэн-Булган чиглэлийн 83км замд 80,502.2 мянга, гүүр арчлалтад 25,758.2 мянга, шуурхай ажлын хэсэгт 129,952.2 мянга нийтдээ 398 км замд 1,148,852.2 мянган төгрөгийн засвар арчлалтын ажлыг хийж гүйцэтгэжээ.

2022 оны зорилтот түвшингээр 1,941,912.7 мянган төгрөгийн орлоготой ажиллахаар төсөвлөсөн ба Зам, тээвэр хөгжлийн яамтай байгуулсан гэрээний дагуу замын сангийн хөрөнгөөр зам засвар арчлалтын ажлыг 1,367,863.9 мянган төгрөгөөр хийж үлдсэн 574,048.8 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн орлогоор бүрдүүлэх төлөвлөгөөг баталсан. Үүнээс Зам тээврийн хөгжлийн яамнаас 1,319,965.4 мянга, Орон нутгийн замын сангаас 584,394.7 мянган төгрөгийн ажил хийж нийт орлого 98.1 хувь буюу 37,552.6 мянган төгрөгөөр тасарсан нь санхүүжилт дутуу байгаатай холбоотой.

Нийт зардалд 1,908,738.2 мянган төгрөг төсөвлөсөн ба 1,911,279.1 мянган төгрөгийг зарцуулсан, төлөвлөгөө 100,1 хувийн гүйцэтгэлтэй, үүнээс удирдлагын зардал 274,729.6 мянган төгрөг төлөвлөснөөс 261,499.3 мянган төгрөгийн зарцуулалттай, гүйцэтгэл 95.2

хувьтай гарч өнгөрсөн онд 262,811.9 мянган төгрөгийн алдагдалтай гарсан нь сэлбэг материал, шатахууны үнэ нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 94,000.0 мянган төгрөг тусгаснаас 20,000.0 мянган төгрөгөөр бага оврын индүү авч, өөрөө буулгагч жижиг оврын машин, 2 ширхэг зөөврийн компьютерыг аваагүй байна.

Төсөвт 200,4 сая төгрөгийн төлбөрийг төлөхөөс 225,1 сая төгрөг төлөгджээ.

#### **4. Аудитын тайлан**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Булган АЗЗА” ТӨХК-ий 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зардал, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Б.Бүжингоо, Б.Гантуяа нар гүйцэтгэж хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

“Булган АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 19 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны нийт орлогын төлөвлөгөөг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан нийт орлогын 1,941,912.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 19,419.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

###### **4.3.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1,

6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Булган АЗЗА” ТӨХК нь өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргаж, бүтэн жилээр мэдээлэх тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хоцроож байршуулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” А-1/947 албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх чиглэл өгчээ. Мөн тээвэр шатахуун, шуудан холбооны зардлыг хэмнэх, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн өглөг, авлагыг бууруулах зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.

“Булган АЗЗА” ТӨХК нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан орон тоог бууруулж ажилласан бөгөөд үүний дотор зөвлөх гэсэн орон тоог хасч, удирдлагын зардлыг 13,230.0 мянган төгрөгөөр хэмнэжээ.

#### 4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитын хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 800.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан, 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт 3: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт.* /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	800.0	1	800.0	100
Албан шаардлага	3	21,848.8	1	9,031.3	33.4
Зөвлөмж	5	1,835.5	4	1,835.5	80
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>24,484.3</b>	<b>6</b>	<b>11,666.8</b>	<b>71.1</b>

#### 4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан “Булган АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын явцад бараа материалын зарцуулалтыг бүрэн гүйцэт шалгах боломжгүй байсан учир дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй юм.

## 5. Аудитын илрүүлэлт

---

Аудитаар нийт 894,495.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,958.8 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 815,423.9 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 75,112.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тус компанийн жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор кассаас дутагдсан 3,550.2 мянган төгрөгийг төлүүлээгүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т *“Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т *“эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

5.1.2. Тайлант онд *“Замын хөдөлгөөний дүрэм”* зөрчсөн албан тушаалтны зөрчил гаргасан 208.6 мянган төгрөгийн торгуулийг эрх мэдлээ хэтрүүлэн байгууллагаас төлсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т *“үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”*, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан контрактын заалтыг тус тус зөрчиж байна.

5.1.3. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, байгууллагын хөрөнгөөр бүсийн спорт тэмцээний бооцооны төлбөрт 200.0 мянган төгрөг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн *“Хангамж, зарим үйл ажиллагаанд тавих хязгаарлалт”* гэсэн 2 дугаар бүлгийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т *“хуулиар зөвшөөрөөгүй бусад”* гэсэн заалтыг зөрчиж байна.

### 5.2 Албан шаардлага

5.2.1. Тайлант хугацааны эцэст 14 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах 213,623.9 мянган төгрөгийн авлагын дүнг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д *“Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэж заасантай нийцээгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2.2. Тус компанийн 1181 БУЛ дугаартай автомашин жилийн эцэст тооллогдоогүй байхад тайлан балансаарх үндсэн хөрөнгийн бүртгэлтэй тулгаж баталгаажуулаагүй, уг машин нь эзэмшигчийн буруу үйлдлээс шатсан, байгууллагад учирсан хохирол 12,800.0 мянган төгрөгийг хариуцагч Н.Отгон-Очироор төлүүлэхээр сум дундын Шүүхийн захирамж гарсан ч төлбөр төлөгдөөгүй, данснаас хасч, авлагад бүртгээгүй байна.

Энэ нь Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т *“Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т *“эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх,*

*бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэж заасантай нийцээгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.2.3.** Өмнөх онд Зам, тээврийн хөгжлийн яамнаас хүлээлгэж өгсөн усны МАЗ /3505/, нөхөөсний БИС /310М/ маркийн тусгай зориулалтын автомашинууд нь тооллогын бүртгэлд байгаа ч үнэ тодорхойгүй шалтгаанаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгагдаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д *“Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна”,* 25 дугаар зүйлийн 25.1-д *“Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ.”* гэж заасантай нийцээгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.2.4.** Байгууллагын автомашинуудын километрийн спидометр ажилладаггүй, явсан км тодорхой бус, шатахууны тооцоо бодолт, тайлан хангалтгүй, зарцуулалтад тавих хяналт сул байнаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”,* Компанийн дүрмийн 10.5-д *“Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ”* гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**5.2.5.** Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргаж, *“Шилэн дансны цахим хуудас”-т* бүтэн жилээр мэдээлэх тайлант оны нийт 589,000,000.00 /таван зуун наян есөн сая/ төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дахь *“Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тайлант онд 67,811.9 мянган төгрөгийн автомашин, механизмын сэлбэг, материалыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэлгүйгээр шууд гэрээ байгуулж, худалдан авсан нь Компанийн дүрмийн 7.13.5 дахь хэсэгт ТУЗ *“гүйцэтгэх удирдлагын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулахад хяналт тавих”* гэсэн заалтын зөрчсөн байна.

##### Өгсөн зөвлөмж:

Компанийн автомашин, механизмын эвдрэл, гэмтлийг техникийн дүгнэлт гаргуулж, өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж, худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулах үйл ажиллагаанд ТУЗ хяналт тавьж ажиллах.

#### **2. Бэлэн мөнгөн зарцуулалттай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Бэлэн мөнгөний гүйлгээний тайланд нярав гарын үсэг зураагүй, нягтлан бодогч хянаж хүлээж авдаггүй, 7,300.0 мянган төгрөгийн хоёр зарлагын баримтын анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, хүлээн авсан хүний үсэг зурагдаагүй байна. Энэ нь

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн, зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Бэлэн мөнгөний гүйлгээний анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж, зарцуулалтад тавих хяналтыг хууль жрмын дагуу хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын тавих хяналтыг сайжруулах.

**3. Дотоод хяналттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Дотоод хяналтын алба нь хяналт шалгалтыг жилийн батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлээгүй нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ажуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7.1-д “зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, үр дүнг тайлагнах”, Компанийн дүрмийн 10 дахь хэсгийн 10.5, 10.6, 10.7 дахь заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Дотоод хяналт шалгалтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэрэгжүүлж, илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгч, үр дүнг ТУЗ-д танилцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс
--------------------	-------------	--------

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тооллогоор дутагдсан бэлэн мөнгийг төлүүлээгүй, авлагаар тусгаагүй	1	3,550.2	1	3,550.2								
Автомашинны торгуулийн мөнгийг байгууллагаас төлсөн	1	208.6	1	208.6								
Тэмцээний бооцооны мөнгийг байгууллага төлсөн	1	200.0	1	200.0								
Авлагыг дүнг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	213,623.9			1	213,623.9						
Автомашиныг данснаас хасч, авлагаар бүртгээгүй	1	12,800.0			1	12,800.0						
Өмнөх онд ЗТХЯ-аас хүлээлгэж өгсөн усны МАЗ /3505/, нөхөөсний БИС /310М/ маркийн автомашинууд нь тооллогын бүртгэлд байгаа ч үнэ үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгагдаагүй	1	-			1	-						
Байгууллагын автомашинуудын километрийн спидометр ажилладаггүй, явсан км тодорхой бус, шатахууны тооцоо бодолт, тайлан хангалтгүй	1	-			1	-						
Сэлбэг, материалыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэлгүйгээр шууд гэрээ байгуулж, худалдан авсан	1	67,811.9					1	67,811.9				
Бэлэн мөнгөний гүйлгээний тайланд нярав гарын үсэг зураагүй, нягтлан бодогч хянаж хүлээж авдаггүй, 7,300.0 мянган төгрөгийн хоёр зарлагын баримтын анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй	1	7,300.5					1	7,300.5				
Дотоод хяналтын алба нь хяналт шалгалтыг жилийн батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлээгүй	1	-					1	-				
Дүн	10	305,495.1	3	3,958.8	4	226,423.9	3	75,112.4				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

